

**Нэр:** Э.Эрдэнэболд

**Мэргэжил:** Эрх зүйч

## **Криптовалютын хүрээнд үйлдэгдэх залилангийн асуудал**

Технологи хөгжихийн хэрээр хүмүүсийн амьдрал улам бүр амар хялбар болж байгаа ч түүгээр дамжуулан үйлдэгдэх аливаа санхүүгийн гэмт хэргийг эрсдэлүүд нэмэгдэж байна. Үүний нэг жишээ нь сүүлийн жилүүдэд хүмүүсийн анхаарлыг ихээхэн татаад буй криптовалюта буюу цахим мөнгөн дэвсгэртийн хүрээнд үйлдэгдэх санхүүгийн гэмт хэргийн асуудал юм. Тодруулбал хуурамч төсөл, койнууд гаргах эсвэл зохиомол үнийн хэлбэлзлийг бий болгох замаар мэдлэг, мэдээлэлгүй иргэдийг их хэмжээгээр хохироох асуудал гарах хандлагатай байгаа юм.

Криптовалют нь виртуал хөрөнгийн нэг төрөл бөгөөд 2008 онд биткойныг бүтээснээр анхны цахим мөнгөн дэвсгэрт (криптовалют)-ийн эхлэл тавигдсан гэж үздэг. Биткойны хувьд хамгийн амжилттай яваа криптовалютаудын нэг юм. Энэ төрлийн криптовалютыг тодорхой нэг этгээд эсвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс удирдах боломжгүй бөгөөд блокчэйн технологи дээр тулгуурлан зөвхөн интернет сүлжээгээр дамжуулан койн эзэмшигчийн зүгээс удирдах боломжтой байдаг<sup>1</sup>. Тухайлбал койныг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэх процессыг блокчэйн технологи бүртгэж байдаг бөгөөд аливаа гуравдагч этгээд (жишээлбэл банк) буюу төрийн эрх бүхий байгууллагын оролцоо, зөвшөөрөл шаардлагагүй байдгаараа онцлогтой.

Цахим орчинд арилжаалагдаж буй койнууд нь бидний өдөр тутмын амьдралд хэрэглэдэг мөнгөн дэвсгэртийг бодвол арилжаалахад харьцангуй амар хялбар боловч блокчэйн дээрх арилжааны мэдээллийг олж авах боломжгүй байдаг. Мөн виртуал орчинд явагдаж байдаг учир хариуцах субъектийг тодорхойлоход хүндрэлтэй тул төрийн эрх бүхий байгууллагаас (цагдаа, тагнуул) хяналт тавих боломж тун хязгаарлагдмал юм. Энэ байдал нь залилах, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх таатай орчин нөхцөл болдог.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд цахим орчинг тэр дундаа мөнгөөр гүйлгээ хийгддэг платформуудыг гэмт хэрэг үйлдэх арга хэрэгслээ болгон ашиглах явдал ихээхэн газар авч

---

<sup>1</sup> М.Түвшинжаргал, “Виртуал хөрөнгийг эрх зүйн үүднээс тодорхойлох нь”, судалгаа, х1, <https://legaldata.mn/b/1032>., 2021 оны 09 дүгээр сард хандав.

байна. PWC<sup>2</sup>-ийн 2020 оны Олон улсын эдийн засгийн гэмт хэрэг, залилангийн судалгаагаар 5000 оролцогч хамрагдан, харилцагчийн залилан, кибер гэмт хэрэг, хөрөнгө завших зэрэг залилангаар нийтдээ 42 тэрбум ам.доллар алдсан нь тогтоогдсон. Энэ дунд хамгийн эрсдэлтэй, их хэмжээний мөнгө алдаж болохуйц цахим хэрэгслүүдийн нэгээр яах аргагүй криптовалютын арилжаа тооцогдож байна. Учир нь цахим мөнгөн дэвсгэрт гэгдэх койнууд нь ямар нэг бүтээгдэхүүн, үнэт зүйлээр баталгааждаггүй виртуал үзүүлэлт гэж хэлж болох бөгөөд үнэ цэнэ нь койныг авах хүмүүсийн эрэлтээр тодорхойлогдож өөрчлөгдөж байдаг. Өөрөөр хэлбэл хэн ч тухайн койныг аваагүй үед үнэ цэнэ нь 0 төгрөг гэсэн үг юм. Энэ нь койн худалдаж авсан хүмүүс их хэмжээгээр мөнгөө алдах эрсдэл өндөр байхын зэрэгцээ аливаа санхүүгийн гэмт хэргийн хохирогч болох магадлал өндөр байгаа юм.

Криптовалюттай холбоотой үйлдэгдсэн залилах гэмт хэргүүдээс хамгийн анхаарал татахуйц их мөнгө залилсан явдал нь Onecoin-ийн кейс бөгөөд энэ нь бүх цаг үеийн хамгийн том крипто луйвар гэж тооцогддог. Одоогийн байдлаар аварга том Понзи схем гэгддэг Onecoin-ийн луйврыг 25 тэрбум ам.доллар залилсан гэж үздэг. Тус хэргийг 2017 онд хааж удирдагч нь 90 жилийн ял сонссон боловч энэ залилан одоо хүртэл үргэлжилсээр байгаа юм. Хамгийн хачирхалтай нь Onecoin хэзээ ч криптовалют болоогүй бөгөөд энэ технологи нь анхнаасаа хуурамч байсан юм. Үүний дараагаар Bitconnect, Pincoin зэрэг луйврууд ордог бөгөөд эдгээрийн хохирлын хэмжээ мөн хэдэн тэрбум ам.доллараар хэмжигддэг.<sup>3</sup> Дэлхийн зарим улсууд криптовалютыг хууль ёсны гэж үзэж гэмт хэрэг, татвартай холбогдох зохицуулалтуудыг хийсэн байдаг бол зарим улсад хуулиар зөвшөөрдөггүй. Жишээлбэл Франц, ОХУ, Сингапур зэрэг улсад криптовалютыг хүлээн зөвшөөрч холбогдох зохицуулалтуудыг хуульчилсан бол Хятад, Өмнөд Солонгос улсууд хэтэрхий өндөр эрсдэлтэйгээс гадна аливаа санхүүгийн гэмт хэрэг үйлдэгдэх таатай орчин нөхцөл болж байна гэж үзсэн тул энэ төрлийн үйл ажиллагааг хориглосон байдаг.<sup>4</sup>

Харин Монгол улсын хувьд виртуал хөрөнгийн арилжааны асуудлыг хориглосон зохицуулалт одоогоор тодорхой бус байна. Ийнхүү тодорхой бус учир ФАТФ-ийн зөвлөмжид орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу аливаа улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй

---

<sup>2</sup> PWC, Аудит, нягтлан бодох бүртгэл, кибер аюулгүй байдал, хувийн нууцлал, засаглал, эрсдэл, татварын үйлчилгээ гэх мэт салбарт зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын компани. <https://www.pwc.com/us/en>,

<sup>3</sup> <https://au.finance.yahoo.com/news/45-bn-lost-5-biggest-crypto-scams-of-all-time-215921732.html> 2021 оны 09 дүгээр сард хандав.

<sup>4</sup> Д.Бямба-Од, “Виртуал хөрөнгийн харилцааг зохицуулах асуудал ба түүнийг санхүүгийн хяналт шалгалтын олон улсын жишигтэй уяалдуулан хөгжүүлэх нь” судалгаа, хб, 2020 он, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1027>, 2021 оны 09 дүгээр сард хандав.

тэмцэх тогтолцоо нь “виртуал хөрөнгө”-д нэгэн адил үйлчлэхээр тогтсон тул виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг батлахаар болсон. Гэвч энэ хуулийн төслөөс харвал зөвхөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид чиглэсэн бөгөөд аливаа эрсдэлтэй, гэмт хэргийн шинжтэй асуудлууд нь Эрүүгийн хуулиар зохицуулагдах юм.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан бол 18 дугаар бүлэгт Эдийн засгийн гэмт хэргийг хуульчилсан. Харамсалтай нь Монгол улс криптовалютыг төлбөрийн эсхүл хөрөнгө оруулалтын аль хэрэгсэлд хамаарах тухай тодорхой хуульчлаагүй тул койнтой холбоотой гэмт хэрэг нь Эдийн засгийн гэмт хэрэгт хамаарах боломжгүй. Харин Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг буюу 17 зүйлийн 17.2.1 дэх хэсэг залилах гэмт хэрэгт хамаарах боломжтой юм. Тус зүйлд “хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, **цахим хэрэгсэл ашиглаж**, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан” бол залилах гэмт хэргийг үйлдсэнд тооцохоор заасан. Криптовалютын хувьд цахим орчинд арилжаалагддаг учир үүнтэй холбогдох аливаа гэмт хэргүүд дээрх зүйл заалтад хамаарахаар байгаа юм.

Виртуал хөрөнгө буюу криптовалюттай холбоотой асуудал нь Монгол улсын хувьд нилээд шинэлэг салбар учир өнөөдрийн байдлаар энэ төрлийн гэмт хэрэг хараахан бүртгэгдээгүй байна. Гэвч цахим орчинд залилуулсан гэмт хэрэг 2015 онд **17**, 2016 онд **69**, 2017 онд **136**, 2018 онд **590**, 2019 онд **641** гэмт хэрэг болж тус тус өссөн бөгөөд 2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийг 2019 онтой харьцуулахад 37.7 дахин<sup>5</sup> буюу жилээс жилд өссөн статистик тоон мэдээлэл гарч байгаа тул криптовалюттай холбоотой гэмт хэргүүд ойрын хугацаанд үйлдэгдэхийг үгүйсгэхгүй. Түүнчлэн сүүлийн саруудад Ард койн, ИН койнууд олны анхаарлыг ихээхэн татаж байгаатай холбоотой хүмүүсийн хандалт өндөр байгааг ашиглан хуурамч төсөл, койнууд гаргах замаар их хэмжээний мөнгө залилах гэмт хэрэг гарах эрсдэл өндөр байна. Учир нь ямар ч этгээд койн зохиох боломжтой бөгөөд интернетэд холбогдсон байхад л хангалттай юм.

---

<sup>5</sup> Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, “Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа”, 2020 он.  
<https://information.police.gov.mn/resource/information/File/2020/11/20/z27fhu56zjwaq6xm/FRAUD1.pdf> 2021 оны 09 дүгээр сард хандав.

Түүнээс гадна зөвхөн хуурамч төсөл, койнуудаар залилах гэмт хэрэг үйлдэгдэх албагүй. Бодит хэрэгжиж буй койнууд дээр ч залилах гэмт хэрэг үйлдэгдэж болох юм. Тодруулбал койн худалдан авагчийн мэдлэг, мэдээлэлгүйг далимдуулах зохиомол байдал бий болгох буюу койны үнийг зориудаар өсгөх, бууруулах замаар залилах гэмт хэрэг үйлдэх боломжтой гэж харж байна. Учир нь койн бол ямар ч бүтээгдэхүүн, үнэт зүйлээр баталгааждаггүй хоосон виртуал үзүүлэлт гэж өмнөх хэсэгт дурдсан. Энэ нь зөвхөн хэдэн хүмүүсийн арилжаан дээр үнэ нь хэлбэлзэж байдаг зүйл юм. Жишээ дурдвал А нь Б-ээс 0 төгрөгийн үнэтэй койныг 100 төгрөгөөр авах захиалга өгч энэ нь баталгаажвал тухайн койны үнэ сүүлд хийгдсэн арилжааны үнийн дүнгээр буюу 100 төгрөгөөр тодорхойлогдох юм. Өөрөөр хэлбэл нийт гаргасан койны ихэнх нь тухайн койныг гаргасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдэлд байхад тухайн этгээдүүд койны үнийг тогтоох боломжтой болно гэсэн үг. Хэрэв койны ихэнхийг эзэмшиж буй этгээдүүд койны үнийг зохиомлоор өсгөвөл мэдээлэлгүй иргэд үүнийг ашигтай койн гэж үзэн их хэмжээгээр худалдан авах магадлалтай. Энэ үед койны үнийг буцаагаад унагах замаар койн худалдаж авсан хүмүүсийг их хэмжээний алдагдалд оруулах боломжтой юм. Үүнийг нэг талаараа залилах гэмт хэргийн шинжийг агуулна гэж харж байна. Учир нь Эрүүгийн хуулийн 17.2.1 дэх хэсэгт “...цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, ...бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж... өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэх авсан бол” энэ төрлийн гэмт хэрэгт хамруулж ойлгохоор заасан. Энэ заалтаас харвал койны үнийг хэсэг бүлэг этгээд зохиомлоор, зориудаар өсгөж улмаар койн худалдан авч буй өмчлөгчдийн мөнгийг шилжүүлэн авсны дараагаар үнийг буулгах явдал нь дээрх гэмт хэрэгт хамаарахаар байгаа юм.

Монгол улсын хувьд хамгийн амжилттай яваа зарим нэг гаргасан койны 90 орчим хувийг долоохон хүн эзэмшдэг<sup>6</sup> гэсэн мэдээлэл байдаг. Энэ нь хэрэв тухайн 7 этгээд нэгдмэл сонирхолтой этгээдүүд бол койны үнийг зохиомлоор өсгөж, бууруулах боломжтой гэсэн үг юм. Өнөөдрийн байдлаар Монголд гарч буй койнуудын хувьд дээрх тохиолдолтой ижил төстэй зүйл ажиглагдаагүй боловч ийм төрлийн койнуудад залилах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл байгаа гэдгийг дурдах нь зүйтэй.

Иймд криптовалюта (койн)-ын үнэ хэн нэг этгээд эсхүл ямар нэг хүчин зүйлийн нөлөөгөөр үргэлж өөрчлөгдөж хэлбэлзэж байдаг тул эрсдэл өндрөөс гадна хоосон чанартай учир залилах гэмт хэргийн хохирогч болж болзошгүй байна. Мөн ийм шинж чанартай байдаг

---

<sup>6</sup> <https://www.coingecko.com/en/coins/> 2021 оны 09 дүгээр сард хандав.

учраас өнөөдөр арилжаалагдаж буй койнууд төлбөрийн хэрэгсэл болон гүйлгээнд ашиглагдах боломжгүй байдаг. Монголчуудын хувьд бага хугацаанд их ашиг олох зорилгоор буюу хөрөнгө оруулалтын хэрэгсэл талаас нь хандаж криптовалютын арилжаа хийх нь элбэг ажиглагддаг. Ийнхүү хөрөнгө оруулахдаа хямдхан койн учир өсөх магадлалтай, маркетинг сайтай байгаа учир найдвартай гэсэн бодлоор их хэмжээгээр нь авах хандлагатай байгаа бөгөөд энэ нь эрсдэл ихтэй юм. Учир нь хэрэв койныг анхны арилжааных нь үед авахад өсөх бололцоогүй эсхүл бүр хуурамч төсөл байсны улмаас залилах гэмт хэргийн хохирогч болох мөн хоёрдогч зах зээлийн үед үнэлгээ нь хөөсөрсөн койн авч бодит үнэлгээн дээрээ очиход хөрөнгө мөнгөөрөө хохирох зэрэг эрсдэл үүсч болзошгүй байдаг. Гэхдээ судалгаа сайн хийж мэдлэг, мэдээлэлтэйгээр арилжаанд оролцоход зарим тохиолдолд ашиг хийх боломжтой гэдгийг үгүйсгэх аргагүй. Ингэхийн тулд аливаа койны үнэ хямд эсхүл үнэтэй байхад ач холбогдол өгөлгүй койн гаргасан этгээдүүдийн мэдээлэл нээлттэй эсэх мөн тухайн гаргасан нийт койны зах зээлийн үнэлгээ хэд вэ зэрэгт анхаарлаа хандуулж хөрөнгө оруулалт хийх нь чухал. Койныг гаргасан этгээдүүд болон койны зах зээлийн нийт үнэлгээний талаар [coinmarketcap.com](http://coinmarketcap.com) эсхүл [coingecko.com](http://coingecko.com) гэсэн сайтуудаар орж мэдээлэл авах боломжтой бөгөөд эдгээр нь олон улсад арилжаалагддаг койнуудын мэдээллийг агуулсан мэргэжлийн сайт юм. Ийнхүү дээрх нөхцөл байдлуудыг ухамсарлах үүднээс тодорхой мэдлэг, мэдээлэлтэйгээр криптовалютын арилжаанд оролцох нь санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болно.

(Үгийн тоо: 1424)

## Ном зүй

1. Д.Бямба-Од, “*Виртуал хөрөнгийн харилцааг зохицуулах асуудал ба түүнийг санхүүгийн хяналт шалгалтын олон улсын жишигтэй уяалдуулан хөгжүүлэх нь*” судалгаа, 2020 он, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1027>,
2. М.Түвшинжаргал, “*Виртуал хөрөнгийг эрх зүйн үүднээс тодорхойлох нь*”, судалгаа, 2021 он, <https://legaldata.mn/b/1032>,
3. PWC, Олон улсын эдийн засгийн гэмт хэрэг, залилангийн судалгаа, 2020 он, <https://www.pwc.com/us/en>,
4. International Compliance Association, “*Financial Crime Compliance Awareness Program*” 2021, <https://www.int-comp.org/>
5. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, “*Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа*”, 2020 он. <https://information.police.gov.mn/resource/information/File/2020/11/20/z27fhu56zjwaq6xm/FRAUD1.pdf>
6. ФАТФ-ийн зөвлөмж 15, <https://www.mongolbank.mn/documents/cma/20180531F2.pdf>
7. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, 2021 он, <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-Tusul-20200118.pdf>
8. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, 2009 он.
9. Эрүүгийн хууль, 2015 он.
10. Finance.yahoo.com, “*5 biggest crypto scams of all time*” <https://au.finance.yahoo.com/news/45-bn-lost-5-biggest-crypto-scams-of-all-time-215921732.html> 2021 оны 09 дүгээр сард хандав
11. Coingecko.com, <https://www.coingecko.com/en/coins/ardcoin> 2021 оны 09 дүгээр сард хандав.